

КЕНИ УЛС: СЭНГВЭР УУГУУЛ ИРГЭД



ТӨРСӨН ГАЗАР НУТГААСАА ХӨӨГДЖЭЭ

Кени улсын Сэнгвэрчүүд маш үзэсгэлэнтэй, асар том Эмбобут ойн сав газрыг эзэмшдэг. Тэд энэ газарт өвөг дээдсийн хамт олон зууны турш амьдарч иржээ. Гэвч Кени улсын Засгийн газар уг нутгаас уугуул иргэд болох малчид, зөгийн аж ахуй эрхлэгчдийг хүчээр хөөн гаргаж байна.

“Дархан цаазат газар” гэх нэрийн дор 2012 оноос хойш ойн хамгаалагч, цагдаа нар 2600 гаруй байшинг шатааж, 4,600 орчим хүнийг орон гэргүй болгосон байна. 2018 оны нэгдүгээр сард нэг хүн буудуулж амь насаа алдаж, бас нэг хүн хүнд гэмтжээ. Эдгээр үйлдэл нь нутгийн уугуул иргэдийг хамгаалах ёстой гэсэн шүүхийн шийдвэрийг шууд зөрчиж байгаа юм.

Сэнгвэрчүүд орон гэр, амьжиргаа, соёл уламжлалаа алдсаар байна. Зарим нь ойгоо орхиж явснаар маш ядуу амьдарч байгаа бол, зарим эрчүүд ойдоо үлдэж эсвэл гэр бүлээ орхиж явсны улмаас эмэгтэйчүүд гэр бүлээ авч явах хүнд ачааг үүрч байна.

Засгийн газар ой мод сүйтгэхээс сэргийлж байгаа гэх боловч үнэндээ Сэнгвэрчүүд ой мод устгаж байгаа талаар ямар ч нотолгоо байхгүй юм. Аж амьдрал, оюун санаа, өвөрмөц онцлог зэрэг нь уугуул иргэдийг Эмбобут ойн жинхэнэ эзэд, байгаль хамгаалагч гэдгийг баталж өгдөг. Тэд газар нутгаа хамгаалахаар шийдсэн. Тэдэнтэй хамт тэмцэцгээ.

Кени улсын Ерөнхийлөгчид хандан
Сэнгвэр уугуул иргэдийг хамгаалахыг
шаардан захидал бичнэ үү.

Uhuru Kenyatta
President of Kenya
Harambee House
PO Box 62345 - 00200 Nairobi
Harambee Avenue, Nairobi, Kenya

Twitter: @UKenyatta

Salutation: Your Excellency